# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# БАЯН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
# ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 01 сарын 27 өдөр Дугаар 09/07 Хөхбүрд

Хэлний бодлогын салбар зөвлөлийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2016 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн "Салбар зөвлөл байгуулах тухай" 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын ээлжит есдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Монгол хэл нь монгол үндэстний оюуны соёлын үнэт өв, үндэсний соёл иргэншлийн язгуур үндэс үндэсний аюулгүй байдал, тумгаар тогтнолын нэгэн баталгаа болсон Хэлний бодлогыг суманд хэрэгжүүлэх салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Дарга- | Сумын Засаг дарга |
| Нарийн бичгийн дарга- | Сургуулийн захирал |
| Гишүүдэд - | Нийгмийн бодлогын мэргэжилтэн |
| | Монгол хэлний багш |
| | Насан туршийн боловсролын менежер |
| | Иргэний төлөөлөл |
| | Соёлын төвийн номын санч |

2.Монгол хэлний тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажлын төлөвлөгөө, тайланг аймгийн Хэлний бодлогын Үндэсний салбар зөвлөлд хүргүүлж зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргад даалгасугай.

4.Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөл байгуулсан 2021 оны 05 дугаар сарын 17-ний өдрийн А/43 дугаар тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Б.ОТГОНБАЯР

648801047